

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
ҮЙЛДВЭР ТЕХНИКИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ



Д. БАЯРСАЙХАН - 2

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ
ОРШИХ “МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН ХӨӨТИЙН
НҮҮРСНИЙ ИЛ УУРХАЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ДУГААР: MV-012199/

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2095025/

БОЛОВСРУУЛСАН:
БАЙГАЛЬ ОРЧНЫ ИНЖЕНЕР

Б. Гэрэлтуяа

/Б.ГЭРЭЛТУЯА/

2024 он

АГУУЛГА

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
УУРХАЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТОГТООСОН НӨӨЦИЙН ТООЦОО, АЖИЛЛАХ ГОРИМ, ТЭЭВЭР	9
ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	10
УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	12
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО, ЗОРИЛТ	13
БҮЛЭГ 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
БҮЛЭГ 2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
БҮЛЭГ 3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
БҮЛЭГ 4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
БҮЛЭГ 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
БҮЛЭГ 6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
БҮЛЭГ 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	22
БҮЛЭГ 9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
БҮЛЭГ 11. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО	28

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн танилцуулга: “Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг билээ. Манай компани уул уурхай, барилгын материал төсөл, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Хөх цав цемент-шохойн үйлдвэрийн төсөл болон дагалдах уурхайнуудын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэхээр 2014 онд “МАК ЦЕМЕНТ” ХХК байгуулагдсан бөгөөд Хөөтийн уурхайн үйл ажиллагааг хариуцдаг билээ.

Компанийн байгаль орчны бодлого

Бидний эрхэм зорилго: Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд байгаль орчинд үүсч болох аливаа сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгахад анхааран ажиллах, байгалийн нөөцийг удаан хугацаанд тогтвортой ашиглах нь компанийн нэн тэргүүний зорилго болно.

Бидний дээдлэх үнэт зүйлс: Компани ба түүний салбар нэгжүүд нь үйлдвэр, уурхайн төслийг боловсруулах шатнаас үйл ажиллагааныхаа бүхий л хүрээнд байгаль орчны асуудлыг анхаарч Монгол улс болон олон улсын хэмжээнд мөрдөж буй уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны холбогдолтой хууль, журам, гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөнө. Эх орон, төрсөн нутаг, усаа хайрлан хамгаалах нь компанийн бүх ажилчид албан хаагчдын үнэт зүйл байх учиртай.

Баримтлах бодлого: Манай компани нь дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг. Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;
- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй дэвшилтэт

технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

- Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц баялгийг ариг гамтай, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргаар ашиглах;

- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ тууштай нэвтрүүлэх;

- Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаархи мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;

- Өөрийн компанийн байгаль орчны талаар баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт зааж таниулах, тавих шаардлагыг өндөржүүлэх замаар байгаль орчны чиглэлээр тэдний хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх;

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ордын ерөнхий мэдээлэл, байршил:

Хөөтийн нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт Говь Угтаал-Баянжаргалангийн өндөрлөгийн төв хэсэгт тогтсон Хөөтийн хотгорт оршино. Ордын тусгай зөвшөөрлийн MV-12199, MV-020297 талбайнуудын газарзүйн солбилцол:


Хүснэгт 1. Ордын газарзүйн солбилцлүүд

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	107 ° 40'00"	45 ° 41'30"	3	107°44'00"	45 ° 40'00"
2	107 ° 44'00"	45 ° 41'30"	4	107°40'00"	45 ° 40'00"

Хөөтийн нүүрсний орд ба хот суурин газрууд, бусад объектуудын байршил:

Хүснэгт 2. Бусад байршил хоорондын зай

№	Хот, суурин газрын нэр	Ордын байршил	
		Зүг	Зай [км]
1	Улаанбаатар хот	Зүүн урагш	300
2	Чойр	Баруун урагш	100
3	Мандалговь	Зүүн хойш	130
4	Баянжаргалан сум Арагтай	Баруун тийш	26



Зураг 1. Хөөтийн нүүрсний ордын байрзүйн зураг

Физик газарзүй: Газрын гадаргын хувьд дунд зэргийн өндөр толгодоор хүрээлэгдсэн гүвээ талархаг байдалтай. Энэ хотгорт байгаа хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1258.2 м өндөр өргөгдсөн Хар тэвш нэртэй уул юм.

Орд нь газар зүйн байрлал болон зах зээлийн хэрэгцээ хэтийн төлөв сайтай дүүрэгт байрладаг. Төмөр замаасаа 125 км зайд, Налайх, Замын-Үүдийн хатуу хучилттай авто замаас 90 км, Шивээ-Овоо-Баянжаргалангийн өндөр хүчдэлийн шугамаас 25 км, Чойр-Таван толгойн авто замын дэргэд оршдог. Ордоос 50 км-ийн дотор зайд эрдэс будаг, барилгын материал, хайлуур жонш, төмөр, цагаан тугалганы хэтийн төлөв бүхий орд илэрцүүд нээгдсэн байдаг.

Байгаль, цаг уурын нөхцөл: Газарзүйн хувьд ордын район нь Говийн мужийн зүүн хойд хэсэгт хамаарагдах бөгөөд хур тунадасны хэмжээ бага, зундаа халуун, өвөлдөө хүйтэн, эх газрын эрс тэс уур амьсгалтай.

Жилийн хамгийн халуун өдрүүд 7 дугаар сарын сүүлчээр үргэлжилдэг бөгөөд дунджаар +23- +30°C, ховор тохиолдолд +40°C-ийн температурт хүрч халдаг. Өвлийн улирал урт 12-3 дугаар саруудад үргэлжилдэг бөгөөд дунджаар -18-28°C заримдаа -35°C хүрч хүйтэрдэг. Хөрсний хөлдөлтийн гүн нь дунджаар 1.5-2.0 м-т хэлбэлзэнэ. Энэ районд Баянжаргалан сумын нэг адилаар ихэнхдээ нутгийн баруун, баруун хойноос чиглэлтэй салхи салхилах бөгөөд салхины хурд нь гол төлөв 4-7 м/сек, заримдаа 14-15 м/сек хүрнэ.

Ургамлын аймаг: Хөрсний бүтэц нь өөрийн тархалт, зузаанаараа харилцан адилгүй

хүрэн, цайвар хүрэн, бор хүрэн, тал нам дор газартаа цайвар шаргал, хужирлаг, өндөрлөг газартаа уулын хүрэн, хүрэвтэр өнгийн хөрсүүд ажиглагдана. Хүрэн цайвар болон бор хүрэн, цайвар шаргал хөрс нь аллювиваль-нуурын гаралтай шавар шавранцараас тогтоно. Хөрсний үений зузаан нь 0.05-0.2 м хааяа 30-40 см хүртэл хэлбэлзэнэ.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг хонхор, хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл, хажуу, нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн. Ургамлын бүрхэвч бүрэлдүүлэгч гол нэр төрлийн өвс ургамал нь шивээт хялгана, хазаар өвс, агь, таана, хөмүүл, зангуу, божмог шарилж зэрэг ургамлууд зонхилсон болно. Дов толгодын гуу жалга, уулсын хажуу нам газраар алтан харгана, хар харгана, дэрс, бүйлс говирхог хэсэгтээ нохойн шийр, бударгана элбэг ургадаг. Өвс ургамлын хувьд уг бүс нь элсэн цөлийн болон говь хээрийн ургамал зонхилно. Ихэнхдээ дэрс, бут, нохойн хошуу, заг гэх мэт ургамлууд элбэг ургадаг.

Амьтны аймаг: Судлагдсан бүс нутаг нь амьтны аймгаар баялаг, элбэг таарах махчин амьтдаас үнэг, хярс, дорго, мануул, хааяа чоно, жижиг мэрэгчдээс үлийн цагаан оготно, орог саарал, шар сүүлт, алаг даага, шөнийн идэвхтэй шавж идэштнээс дэлдэн зараа, сарьсан багваахайнууд, туулай зэргийг нэрлэж болно. Энэ хэсгээр хамгийн өргөн тархсан нь тарвага, хар сүүлт, цагаан зээр ихээр нутаглан амьдарна.

Дулааны улиралд тогоруу, тоодог, турлиах нүүдэллэн ирдэг ба энэ нутагт байнга оршин байдаг шувуудаас бүргэд, элээ, хон хэрээ, харцага, талын сар, нөмрөг тас, шар шувуу, болжмор, ногтруу, ууль, хөх цөцгий, тагтаа, чогчиго, хулан жороо гэх мэт жигүүртнүүдийг нэрлэж болно. Мөн хоёр нутагтан, хэвлээр явагчаас бамбай хоншоорт могой, рашааны могой, хонин гүрвэл, могой гүрвэл, шавж болон жижиг далавчитнаас царцаа, голио, зөгий, хөх түрүү, соно зэрэг амьтад элбэг амьдардаг бүс нутаг юм.

Дэд бүтэц: Хөөтийн нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 300 км, төмөр замын зангилаа бүхий Чойр хотоос баруун урагш 100 км, аймгийн төв Мандалговь сумаас зүүн хойш 130км, Баянжаргалан сумын төв Арагтайгаас баруун тийш 26 км зайд Хөөтийн хотгорт оршино.

Зам тээврийн нөхцөл: Орд нь бүтэн жилийн турш бусад хот сууринтай зам тээврээр холбогдох боломжтой бөгөөд Улаанбаатар хотоос төмөр замын Чойр өртөө болон Говь-Сүмбэр аймгийн төв хүртэл асфальтан замаар, цааш Говь-Сүмбэр аймгийн төвөөс орд хүртэл шороон замаар холбогдоно.

Уурхайн усан хангамж: Газрын доорхи ус нь Хөөтийн нүүрсний ордын хэмжээнд газрын гадаргуугаас 2.2-12.04 м гүнд байрлах ба усны түвшний байрлал нь ерөнхийдөө гадаргуугийн хотгор гүдгэрийн хэв шинж болон түрэлтийн хэмжээнээс хамааран янз бүрийн гүнд байрлана.

Уурхайн унд, ахуйн усыг 26 км-т байрлах Баянжаргалан сумын гүний худгаас зөөврөөр хангадаг.

2024 онд Хөөтийн нүүрсний уурхай нь 20-25м гүнтэй ус муу агуулдаг нүүрслэг аргиллит, алевролит, аргиллит зэрэг тунамал чулуулгийг хамарч уулын ажлыг явуулах бөгөөд жилд унах хур тунадасны хэмжээ, уурхайн суулттай холбоотойгоор хоногт дунджаар 535 м³ ил зумпфын аргаар ажлын талбайд ус таталтын ажлыг цаг тухай бүрд нь явуулна. Ус цуглуулах зумпфыг уурхайн ёроолд ахилт багатай талд байрлуулж усыг цуглуулж Насос ДК-315 маркын насосоор татаж уурхайн зам талбай, ногоон байгууламж услах ажилд ашиглана.

Хүснэгт 3. Унд ахуйн усны хэрэглээ

Монгол улсын Засгийн газрын 2013.09.20-ны өдрийн 326,327 дугаар тогтоолоор унд ахуйн усыг чөлөөлсөн тул тооцоонд хамтад нь авсан.	тн/хоног	тн/сар	тн/жил
	20.46	613.8	7,365.7

Хүснэгт 4. Ил уурхайн шүүрлийн усны тооцоо

Насосны марк	Даралт шахах өндөр, м	Бүтээл, м ³ /цаг	Бүтээл м ³ /хоног т	Бүтээл м ³ /сар	Бүтээл м ³ /жил	Уурхай нийт 305 хоног тасралтгүй 2 ээлжээр ажиллана. Ус шүүрүүлэлтийн ажил 275 хоног хийгдэнэ.
Насос ДК-315	1	2	3	4	5	
	10	20	535	16050	144,450	

Хүснэгт 5. Зам усалгаа

Орд ашиглалтын жил	Замын хэмжээ			Хоногт услах давтамж	Зам усалгааны машин				Усны зарцуулалт	
	Усалгааны замын урт, м	Зорчих хэсгийн өргөн, м	Талбай м ²		Зам усалгааны цестерний багтаамж, тн	Тоо ширхэг	Усалгааны үеийн хурд, км/цаг	Усалгаанд зарцуулах хугацаа, цаг/хон	Хоногт зарцуулах усны хэмжээ, м ³	Жилд хэрэглэх усны хэмжээ, м ³
2024	2500	16	40,000	1-2	40	1	5	2	40	6609.1

Ил зумпфын гүн нь 1.5м өргөн 2.5м байх бөгөөд дээрх усны насосаар соруулан Белаз-76473 маркын зам усалгааны машинд хийж уурхайд үүсэх тоосжилтыг дарахад ашиглана. Шүүрлийн усыг соруулан авч 16м өргөнтэй 1,0-2,5 км урт уурхайн доторх зам болон уурхайгаас овоолго хүрэх зам талбайг усалхаар тооцов.

Унд ахуйн усыг 26 км-т байрлах сумын худгаас зөөврөөр ашиглана. Хөөтийн ордын орчимд борооны уснаас үүдэлтэйгээр тойромд тогтдог шорвог нуурыг эс тооцвол гол нуур зэрэг ил задгай ус байхгүй. Хөөт, Шар даравгай зэрэг ганц нэг булаг байвч ундны

хэрэгцээнд тохиромжгүй эрдэсжилт ихтэй.

Уурхайн цахилгаан хангамж: Уурхайн гадаад цахилгаан хангамжийн хэлхээнд Чойр 220/110/35/6кВ-ын дэд станцаас (Хөөт) 35/6кВ-ын дэд станцын нээлттэй хуваарилах байгууламж хүртэлх хэрэглэгчид цахилгаан тоног төхөөрөмжүүд хамаарна. Хөөтийн 35/6кВ-ийн дэд станц нь Баянжаргалан 35/10кВ-ийн дэд станцын 35кВ-ийн шугамаас салбарлан тэжээгдэж байгаа ба агаарын шугам, ил болон хаалттай хуваарилах байгууламж дахь тоноглол нь бүгд өмнө нь ашиглагдаж байгаагүй шинэ тоног төхөөрөмжүүд юм.

Уурхайд ашиглагдах техник тоног төхөөрөмж: 2024 онд уурхайн үйл ажиллагаанд хэрэглэгдэх тоног төхөөрөмжүүдийг доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 6. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүдийн судалгаа

№	Төрөл	Марк	Хүчин чадал	Тоо/ширхэг	Зориулалт
1	Экскаватор	Hyundai 850	4.8 м ³	1	Хөрс хуулалт
2	Экскаватор	CAT-395	6.5 м ³	1	Хөрс хуулалт болон нүүрс олборлолтонд ачилт хийх
3	Экскаватор	ЭКГ-10	10 м ³	1	Хөрс хуулалт болон нүүрс олборлолтонд ачилт хийх
4	Автосамосвал	75135	110 тн	2	Хөрс болон нүүрсний цэвэрлэгээ тээвэрлэх
5	Автосамосвал	Хово-371	50 тн	3	Хөрс болон нүүрсний цэвэрлэгээ тээвэрлэнэ
6	Белаз	76473	32 тн	1	Зам талбай услах, чийгшүүлж тоос дарах
7	Бульдозер	CAT D9R	18.5 м ³	1	Шимт хөрс хуулалт, ул таазны цэвэрлэгээ болон овоолгын ажилд
8	Автогрейдер	CAT 160H		1	Овоолго, зам болон мөргөцгийг тэгшлэх

CAT-160K Автогрейдер нь уурхайн хөрс хуулалтын болон нүүрс олборлолт, уурхайн гадаад тээвэрлэлтийг хурдасгаж машинуудын дугуйны элэгдлийг багасгах зорилгоор зам тэгшилж, цэвэрлэх ажлыг гүйцэтгэнэ.

Уурхайн барилга байгууламж: Уурхайн ажилчдын ажиллаж амрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор дараах барилга байгууламжуудыг барьж байгуулан ашиглаж байна. Үүнд:

- Ажилчдын амрах байр, бусад барилга байгууламж
- Уурхайн захиргаа
- Засвар үйлчилгээний төв, хаягдал тос хадгалах түр цэг
- Шатахуун түгээх станц
- Харуулын пост, хашаа
- Лаборатори
- Ус цэвэршүүлэх, бохир ус цэвэрлэх байгууламж гэх мэт

УУРХАЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТОГТООСОН НӨӨЦИЙН ТООЦОО, АЖИЛЛАХ ГОРИМ, ТЭЭВЭР

Нөөцийн тооцоо: 2007-2011 онуудад Хөөтийн нүүрсний ордын 12199А тусгай зөвшөөрлийн талбай дээр ерөнхий эрэл, эрэл үнэлгээ, нарийвчилсан хайгуулын ажлуудыг үе шаттайгаар гүйцэтгэн явуулсны үр дүнд нүүрсний геологийн нөөцийг дахин бодож А+В зэргээр 31,763,380.43 тн гэж тооцоолсон болно.

Хөөтийн нүүрсний ордын нүүрсний давхраас нь нарийн нийлмэл тогтоцтой хагарал эвдрэлд орсон ба нүүрсний чанарыг дундажлан харуулбал: 16.62%-ийн үнслэгтэй, 44.73%-ийн дэгдэмхий бодисын агуулгатай, 13.45%-ийн ажлын чийгтэй, 0.97% хүхрийн агуулгатай, 4715.83 ккал/кг шаталтын дулаан бүхий чулуун нүүрс юм.

Техник эдийн засгийн үндэслэлийн дагуу ашиглалтыг явуулж 2024 оны уулын ажлын төлөвлөлтөөр 1195-1165 метрийн түвшин хүртэл гүнзгийрч нийт 1,5 сая,м³ хөрс хуулж, 550 мян.тн нүүрс олборлох зорилтыг биелүүлэхээр ажиллана.

Хүснэгт 7. Уурхайн 2024 оны уулын ажлын төлөвлөгөө

Хөөтийн Нүүрсний Уурхай			
Хөрс хуулалт	Цэвэрлэгээ	Нүүрс олборлолт	Уулын цул
м ³	м ³	тн	м ³
1,568,339	66,000	550,000	2,168,339
Хөрс хуулалтын коэффициент, м ³ /тн			2,97

Хүснэгт 8. 2024 оны олборлолтонд өртөх нөөц (Чулуун үетэй нүүрс)

Блокын дугаар	Давхаргын дугаар	Нөөц (Эдийн засгийн үр ашигтай нөөц)	2023 оны эцсийн байдлаар, тн	2024 онд өртөх нөөц, тн
А зэрэглэлийн нөөц		4,794,785.94	4,423.75	330,000
В зэрэглэлийн нөөц		22,212,232.85	22,018.42	220,000
С зэрэглэлийн нөөц		6,046,396.77	6,044.95	-
Бүгд нөөц		33,053,415.56	32,487.120	550,000

Ил уурхайн ажиллах горим: 2024 онд Хөөтийн уурхайн ажиллах горимыг МАК-ын уурхайнуудад мөрдөгдөж буй дараах байдлаар тасралтгүй ажиллагаатайгаар ажиллана.

Хүснэгт 9. Уурхайн ажлын горимын үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Хэмжих	Хэмжээ	Тайлбар
1	Жилийн ажлын горим	Тасралтгүй		
2	Жилийн календарьт хугацаа	хоног	365	
3	Жилд ногдох ажлын бус хоног	хоног	30	Баяр ёслол
4	Цаг агаарын саатал хүндрэл	хоног	5	
5	Жилд ажиллах хоног	хоног	308	
6	Хоногийн ажлын горим	ээлж	2	
7	Ээлжийн хугацаа	цаг	12	

Ажиллах хүчний мэдээлэл: 2024 оны Уурхайн бүтэц орон тоо 276 хүнээр батлагдсан. Үүнээс нэг ээлжинд 60-70 хүн ажиллана.

Уурхайн нүүрс олборлолт болон тээвэрлэлт: Нүүрсний зах зээлийн хэрэгцээ шаардлага, уурхайн техникийн хүчин чадалд тохируулан 2024 онд хаягдал, бохирдлыг тооцон 550 мян.тн нүүрс олборлож, 335 мян.тн нүүрсийг борлуулахаар төлөвлөсөн. Цемент шохойн үйлдвэр, Хийт бетоны үйлдвэр, болон бусад гэрээт компаниуд болон орон нутгийн хэрэглэгч нарт худалдан борлуулна.

Нүүрс олборлолтын ажлыг мөргөцгөөс шууд ачих бөгөөд нүүрс тээврийн машины тээх чадвартай уялдуулан өгсөх уурхайн үндсэн траншей замын налуу 80 промилль-р тооцож байгуулна. Уурхайгаас гадаад тээврийг 130км зайд Олон Овоот өртөөнд байрлах нүүрс борлуулах хэсэгрүү тээвэрлэнэ. Нүүрс олборлолт болон цэвэрлэгээний ажилд САТ-395 экскаватор ажиллана.

ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Засаг захиргаа, нутаг дэвсгэр: Дундговь аймаг нь Засаг захиргааны хувьд 16 сум, 66 багтай, 7469.0 мянган га нутаг дэвсгэртэй, газар нутгийн хэмжээгээр Монгол улсын нутаг дэвсгэрийн 4.5%-ийг эзэлдэг, аймгийн төв Улаанбаатар хотоос 265 км-т байрладаг. Төв, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай аймгуудтай хиллэдэг.

Баянжаргалан сумын төв нь Улаанбаатар хотоос 300км, аймгийн төвөөс 150 км-т, Говьсүмбэр аймгаас 80 км зайтай. Өөрийн аймгийн Өндөршил, Гурвансайхан, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдтай, Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь, Дорноговь аймгийн Даланжаргалан сумдтай тус тус хиллэн оршдог.

Газрын гадарга, хөрсний бүтэц: Аймгийн нутаг дэвсгэрийн хилийн тойрог 1230 км, нутгийн баруун цэгт Гучингийн худгаас зүүн цэг Хөх дэл хүртэл 425 км, хойд цэг Ус хар толгойгоос урд цэг Өвөр цагаан дэрс хүртэл 283 км. Нийт газар нутаг нь тал хээр говийн бүсэд багтдаг. Тэгш тал газрын хамгийн өндөр нь далайн түвшнээс дээш 1530 м, хамгийн нам нь 980 м, далайн түвшнээс дээш 1913 м өндөр өргөгдсөн байдаг. Тус аймгийн нутаг уулын хөрс /хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн/ маш бага хувийг эзэлж Адаацагийн хойд тал, Бага газрын чулуу, Угтаалын уул, Их газрын чулуу орчимд тархсан. Нутгийн төв, хойд хэсгээр ухаа толгод нам уулсын /хүрэн, цайвар хүрэн, цөлөрхөг хээрийн бор, хээр цөлийн бор/ хөрс, нутгийн төв, өмнөд хэсгээр тал хөндийн /цөлөрхөг хээрийн 20 төрлийн хөрс / хөрс тархсан.

Уур амьсгал: Аймгийн нутаг дэвсгэрийн уур амьсгалын хувьд хуурай, сэрүүн, уулын хээрийн муж /Эрдэнэдалайн хойд хэсэг, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэнгийн хойд хэсэг/, нэн хуурай дулаавтар, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Луус, Гурвансайхан, Өндөршил сумын хойд хэсэг, Сайхан-Овоо, Сайнцагаан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан сумдын нутаг/, нэн хуурай дулаан, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай,

Хулд, Гурвансайхан сумдын урд хэсэг, Өлзийт сумын нутаг/ гэж 3 хуваадаг. Агаарын температурын дундаж хэмжээ өвлийн сард -16-19 градус, зуны сард +17-21градус, жилд орох хур тунадасны хэмжээ 95-150мм унадаг.

Нийгэм эдийн засаг: Баянжаргалан сумын нийт хүн амын тоо 1276, нийт хүн амын 52.3% нь-г 16 хүртэлх насны хүүхэд, 34.6%-г хөдөлмөрийн насны хүн ам эзэлдэг. Иргэдийн хүйсийн бүрдэл харьцангуй тогтмол бөгөөд сумын нийт иргэдийн 30 гаруй хувь төвдөө амьдардаг байна. Нийт өрх 443, үүнээс малчин өрх 263 өрхтэй. Нийт өрхийн 112 өрх нь Шилийн гол багт, 151 өрх нь Энгэр-Ус багт, 180 өрх нь Арагтай багт амьдрах бөгөөд 2019 оны байдлаар 2018 оноос 6.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Ажил эрхлэлт: Баянжаргалан сумын ажиллах хүчний оролцооны түвшин 15 ба түүнээс дээш насны иргэдээр тооцвол 65.5%-тай байх бөгөөд насны бүлгээр задалбал, сумын хэмжээнд 34-44, 44-54 насны бүлгийнхэн түвшин бусад насны бүлгийнхэнтэй харьцуулахад харьцангуй өндөр байна. Хийгдсэн судалгаанаас харахад сумын өрхийн 50 орчим хувь нь албан ажил хийдэг гишүүнтэй бөгөөд үлдсэн 50 гарам хувь МАА эрхэлдэг байна. Харьцангуй олон мал аж ахуй эрхлэгчид байгаа нь тухайн иргэдийн уламжлалт сэтгэлгээтэй, мөн тухайн орон нутгийн дэд бүтэц муу хөгжсөн, ажлын байр дутмаг, тэтгэвэрт гарсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажил хөдөлмөр эрхлэх насанд хүрээгүй гишүүн олонтой байна.

Ажилгүйдлийн түвшинг хүн амын ялгавартай шинж байдлаар харвал, эмэгтэйчүүд, залуу насны бүлгийн, бүрэн бус болон бүрэн дунд боловсролын түвшинтэй хүн амын хувьд ажилгүйдлийн түвшин бусдаас харьцангуй өндөр байна. Айл өрхийн ажиллагчдын тоог эдийн засгийн үйл ажиллагааны голлох салбараар гаргаж үзүүлснээр бол албан ажлын хувьд төрийн байгууллага, уул уурхайд ажиллах хүмүүсийн тоо өндөр байгаа бөгөөд албан бус ажил буюу мал маллах ажлыг сумын иргэдийн ихэнх нь хийдэг байна.

УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Агаарын чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл: Уурхайн олборлолт, боловсруулалтын үед хөрс хуулах, түрэх, тээвэрлэх зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автосамсомалоос хорт хий ялгарах, уурхайн байрлаж буй хэсэг нь хуурай уур амьсгалтай, салхи шуурга ихтэй, говь цөлийн бүс бөгөөд ургамлан бүрхэвч тачир сийрэг, нимгэн давхаргатай хөрс тул тоосжилт ихээр үүсэх боломжтой юм.

Хөрсний чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл: Хөөтийн уурхай орчмын хөрс нь шим тэжээлийн түвшингээр тааруу, ялмагийн агууламж бага 0.24-2.96%, элсэнцэр, элсэрхэг хөнгөн механик бүрэлдэхүүнтэй учир элэгдэл эвдрэлд орохдоо амархан хөрс юм.

Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл:

Усны эх үүсвэр болох худгийн ойр орчимд гүний усыг бохирдуулах үйл ажиллагаа явуулах, урсгалын эхэнд ус бохирдуулах үйл ажиллагаа явуулах (машин угаах, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал хаях), шатах тослох материал хөрсөнд асгарах зэрэг нь хөрсний сул ус болон хур тунадасаар дамжиж ундны ус цаашлаад гүний усыг бохирдуулах магадлалтай.

Амьтан, ургамлын зүйлийн бүрдэлд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл: Хөрс хуулалт, нүүрс тээврийн үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэлд орж ургамлан нөмрөг, тэжээллэг ашигт ургамлын зүйл буурах аажмаар алга болох эрсдэлтэй.

Нүүрс олборлолт, тээврийн үед их хэмжээгээр тоосонцор агаарт дэгдэх үед нарны цацрагийн шууд тусгалыг хаах түүний нөлөөгөөр ургамлын ургалт багасч анхдагч бүтээгдэхүүний бүтээмж буурах, уурхайн үйл ажиллагаа, дэд бүтэцтэй холбогдон ан амьтны байршил нутаг алдагдах, чимээ шуугиан, гэрлийн нөлөөгөөр ан амьтан үргэх, дайжих магадлалтай.

Түүх, соёлын дурсгалт зүйлст нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл:

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт өмнө нь хийгдсэн хайгуулын ажлын үед болон Монголын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн хийсэн судалгаанаас үзвэл түүх дурсгалын болон соёлын өв бүртгэгдээгүй байна.

Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл:

Үйл ажиллагааны явцад ажилчид ажлын хариуцлага алдах, технологийн горим, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг хянах хяналт суларснаас янз бүрийн болзошгүй осол гарч хэвийн ажиллагаа саатаж тоног төхөөрөмж эвдрэх, байгууллага, эдийн засгийн хохирол учрах, улмаар хүний эрүүл мэндэд эрсдэл учирч болзошгүй.

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Хөөтийн уурхай нь 2024 онд техник эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажлын төлөвлөлтийг 1195-1165 метрийн түвшин хүртэл гүнзгийрч нийт 1,5 мян,м³ хөрс хуулж, 550 мян.тн нүүрс олборлох зорилтыг биелүүлэхээр ажиллана.

Уулын ажлын үйл ажиллагаанаас гарч болзошгүй гол болон сөрөг нөлөөллүүдийг тодорхойлон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, түүнийг багасгаж бууруулах арга замыг уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд багтаасан болно.

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас урган гарах сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дагуу төлөвлөгөөт ажлуудыг авч хэрэгжүүлэн нөлөөллийн утгыг хамгийн бага түвшинд байлгахад оршино.

Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллана.

Үүнд:

- Байгаль орчны хяналтаар илэрсэн сөрөг нөлөөллийг цаг алдалгүй илрүүлж, арилгах арга хэмжээг зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг хуваарийн дагуу гүйцэтгэх
- Байгаль орчны чиглэлээр орон нутагтай хамтран ажиллах хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

БҮЛЭГ 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд, шинээр гарч буй шаардлагатай уялдан байнга шинэчлэгдэж байх баримт бичиг төдийгүй уурхайн үйл ажиллагааны үед байгаль орчныг хамгаалах, нэгэнт бий болсон сөрөг нөлөөллийг бууруулж, нөхөн сэргээх замаар байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх арга замыг тодорхойлно.

1.1 Агаар орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд:

Зорилго: Уурхайн ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны тэнцлийг хадгалах зорилгоор орчны агаар дахь хими, физикийн гаралтай түгээмэл бохирдуулагчийг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхад оршино.

Хүснэгт 10. Агаарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөөтийн нүүрсний ил уурхайн олборлолтын үеийн үйл ажиллагаа	Тоосжилтын эх үүсвэрүүдийг чийгшүүлэх	Төслийн талбай	-	-	-	1,500,000	Жилийн турш	Агаарын тухай хууль /шинэчилсэн найруулга/
2		Дотоод замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хурдны хязгаарт хяналт тавих	Төслийн талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	
Нийт							1,500,000		

1.2 Усан орчинг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд:

Зорилго: Уурхайн ажилчдын амьдрах орчинд ямар нэгэн бохирдолгүй усыг унд ахуйд хэрэглэх, уурхайн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

Хүснэгт 11. Усан орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөөтийн ил уурхайгаас нүүрс олборлох явцад шүүрлийн усыг шавхсанаас талбай орчмын газрын доорх усны нөөцөд нөлөөлөх	Уурхайн шүүрлийн усны тоолуурыг суурилуулах, салгах тохиолдолд сумын байгаль орчны мэргэжилтнийг байлцуулах, шавхсан усыг автозамын усалгаанд эргүүлэн ашиглах	Төслийн талбайд	-	-	-	1,500,000	Тухай бүр	Усны тухай хууль /шинэчилсэн найруулга/
Нийт							1,500,000		

1.3 Газрын гадарга, хэвлий хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд:

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлий эвдрэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Хүснэгт 12. Газрын гадарга, хэвлийд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	ЗҮТ, ШТС-ийн үйл ажиллагаанаас газрын гадаргыг бохирдох	ШТМ-ын хадгалалт, асгаралтанд хяналт тавих, асгаралт үүссэн тохиолдолд бохирдсон хөрсийг хуулан саармагжуулах.	Уурхайн талбай	-	500,000	-	500,000	Тухай бүрт	Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад хууль,

2	Хөөтийн нүүрсний орд төслийг ашиглах явцад уурхайн дотоод болон тээврийн зам эвдрэлд өртөнө.	Уурхайн болон тээврийн замын урсгал засваруудыг цаг тухайд нь хийх	Уурхайгаас Баянжаргалан сум хүртлэх тээврийн зам	-	2,000,000	-	2,000,000	Тухай бүрт	холбогдох дүрэм журам, стандарт
Нийт							2,500,000		

1.4. Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгийг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд:

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулж, Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжин ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, уурхайгаас хуулсан шимт хөрсний үржил шимийг алдагдуулахгүйгээр хадгалах, арчлах

Хүснэгт 13. Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Шимт хөрсний овоолгын удаан хугацааны хадгалалтаас өнгөн хөрсний үржил шим тэжээлийн алдагдал буюу ялзмагийн хувь хэмжээ багасах	Уурхайн олборлогын явцад хуулсан шимт хөрсийг стандартын дагуу хадгалж, овоолго үүсгэн салхинд хийсэх, усанд автах, хаягдал чулуулгийн овоолго болон бусад материалаар бохирдохоос хамгаалах	Шимт хөрсний овоолго	-	-	-	Үйл ажиллагааны зардалд туссан	Жилийн турш	MNS 4920:2000 Байгаль орчин. Эвдэгдсэн газрын налуу. Техникийн шаардлага MNS 5916:2008 Байгаль орчин. Үржил шимтэй хөрсийг зайлуулахад тавигдах

2	Төслийн талбай орчмын ургамлан нөмрөг багасах	Уурхайн суурингийн ногоон байгууламжийг арчлан тордож, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Уурхайн талбай	-	3,000,000	2 удаа	6,000,000	Жилдээ	шаардлага ба хөрсийг ухах хугацаанд түр хадгалах
Нийт							6,000,000		

1.5 Амьтны аймаг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд:

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас амьтны аймагт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулж, бүртгэл судалгаа хийхэд оршино.

Хүснэгт 14. Амьтны аймагт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ил уурхайн нүх, ухмал, шуудуунд мал, амьтан орж үрэгдэж болзошгүй.	Уурхай орчмын барилга байгууламжуудыг тойруулан хашсан торон хашаа, далан шуудууны бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах ба нурж эвдэрсэн тохиолдолд засаж мал, амьтан нэвтрэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх.	Уурхайн талбайд	-	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль /шинэчилсэн найруулга/
2	Уурхайн үйл ажиллагаанаас уурхайн	Цаг агаар хүндэрч бэлчээр нутгийн ан амьтан идэш	Уурхайн талбайд	-	-	Тухай бүрт	3,000,000	Жилийн турш	

	орчмын бэлчээрийн талбай болон нүүдлийн туруутан амьтадын нүүдлийн зам уг замаар тусгаарлагдах.	тэжээлээр дутмаг үед мал амьтдад өвс, тэжээл тавьж өгөх зэргээр зориудын тэтгэх (биотехникийн) арга хэмжээ авах							
3	Уурхайд ажиллаж байгаа ажиллагсдын тоо нэмэгдэж хууль бусаар ан хийх магадлал нэмэгдэж болзошгүй.	Уурхайн талбай орчимд харагдсан амьтадын бүртгэлийг уурхайн ажилчдын оролцоотойгоор бүртгэн амьтдын тархалт, байршлын талаар мэдээллийг цуглуулах	Уурхайн орчимд	-	-	Тухай бүрт	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	
Нийт							3,000,000		

БҮЛЭГ 2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 15. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайг хаах, байгаль орчныг нөхөн сэргээх зардлын санг жил бүр хуримтлуулах	Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг тусгай дансанд байршуулах	удаа	1	-	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад хууль, холбогдох дүрэм

								журам, стандарт
Нийт зардал							-	

БҮЛЭГ 3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөөтийн нүүрсний уурхайн 2024 оны дүйцүүлэн хамгаалах ажлыг Дундговь аймгийн БОАЖГ болон Баянжаргалан сумаас санал авсаны үндсэн дээр дүйцүүлэн хамгаалах ажлыг хийнэ.

Хүснэгт 16. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ, биологийн олон янз байдлыг сайжруулах	Баянжаргалан сумын хогийн цэгийн шинэчлэл сайжруулалтыг хийж хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх	Орон нутгийн саналын дагуу	-	-	40,000,000	Жилдээ	Холбогдох хууль тогтоомж, Хамтын ажиллагааны гэрээ
Нийт зардал						40,000,000		

БҮЛЭГ 4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөлөөллийн бүсийн иргэнтэй нөхөн олговор олгох гэрээг хийж 2023 онд шийдвэрлэсэн.

БҮЛЭГ 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд түүх, соёлын өв дурсгалууд илрээгүй болно.

БҮЛЭГ 6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөөтийн ордоос нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх Хөөтийн нүүрсний орд төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн сөрөг нөлөөллийг хурдан хугацаанд арилгахад

оршино.

Хүснэгт 17. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Технологийн хэвийн ажиллагааны горим алдагдах	Технологийн хэвийн ажиллагааны горим алдагдахаас урьдчилан сэргийлж үзлэг оношилгоог тогтмол хийх, байнгын хяналт тавих	Уурхайн хэмжээнд	Тухай бүрт	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны тухай хууль болон Аюулгүй ажиллагааны зааварчилгаа
2	Ажилчдын эрүүл мэнд, бие махбодид учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, бэртэл, гэмтэл	Өндөр хүчдэл, цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг ханган ажиллах	Нийт ажилтан	Тухай бүрт	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	
3		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан болон давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах, бүртгэлжүүлэх	Нийт ажилтан	Тухай бүрт	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	
4		Хөдөлмөр хамгаалал, байгаль орчны чиглэлээр үзлэг шалгалт хийж уурхайн удирдлагад тайлагнаж, үл тохирлыг арилгаж ажиллах	Нийт ажилтан	Тухай бүрт	-	200,000	Жилийн турш	
5	Байгаль, цаг уурын хүчин зүйл	Үер ус, салхи шуурга, аянга цахилгаан, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, ажилчдад сэрэмжлүүлэг мэдээлэл өгөх	Нийт ажилтан	Тухай бүрт	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	
Нийт зардал						200,000		

БҮЛЭГ 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн шингэн болон хуурай хог хаягдлын нөлөөгөөр байгаль орчин бохирдохоос урьдчилан сэргийлэх, ямар нэгэн байдлаар бохирдсон тохиолдолд тухайн сөрөг нөлөөллийг хурдан хугацаанд арилгахад оршино. Хог хаягдлаас үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээг доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдалын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлын гэрээ байгуулах, үүссэн хог хаягдлаа тогтмол зайлуулах	Уурхайн хэмжээнд	-	-	Тухай бүрт	Үйл ажиллагааны зардалд туссан	Жилдээ	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон холбогдох тогтоол, дүрэм, журам
2		Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах	Уурхайн хэмжээнд	Удаа	50,000	2	100,000	Жилдээ	
3	Дахивар	Үүсэх хог хаягдлыг ангилан ялгаж дахивар авах цэгт хүлээлгэн өгөх	Уурхайн хэмжээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардалд туссан	Жилдээ	
4	Аюултай	Тос тосолгооны материалын үлдэгдэл хаягдлыг ил задгай хаяхгүй байх, тусгай талбайд зориулалтын битүүмжлэлтэй цэгт хуримтлуулах,	Уурхайн хэмжээнд	-	-	Урьдчилан тооцох боломжгүй	Үйл ажиллагааны зардалд туссан	Жилдээ	

		мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх							
Нийт зардал						100,000			

БҮЛЭГ 8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт шинжилгээний хөтөлбөрийг БОННУ-нд зөвлөмж болгосны дагуу тодорхойлсон хяналтын цэгүүд дээр, хуваарийн дагуу явуулж уурхайн үйл ажиллагаанаас үүсэн гарах нөлөөллийг хянах, хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах явдал юм. Мэргэжлийн байгууллагаар жилдээ 2 удаа хяналтын цэгүүдээс дээж авж шинжлүүлнэ. Дотооддоо ажлын байран дахь дуу чимээг TESTO815 гэсэн багажуудаар хэмжилт, мониторинг хийнэ.

9.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ

Хүснэгт 19. Агаарын чанарын хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Ялгарах бохирдуулагчид: SO ₂ , CO, NO ₂	Технологийн зам	Хавар, намар	Жилд 2 удаа	100,000	200,000	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016
		Уурхайн карьер					
		Ажилчдын хотхон орчим					
		Нөлөөллийн бүс					
2	Тоосны хэмжилт: PM ₁₀ , PM _{2.5}	Технологийн зам	Хавар, намар	Жилд 2 удаа	60,000	120,000	
		Уурхайн карьер					
		Ажилчдын хотхон орчим					
		Нөлөөллийн бүс					
Нийт						320,000	

9.2 Хөрсний хяналт шинжилгээ

Хүснэгт 20. Хөрсний хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Хөрсний хими физик шинж чанар	Шимт хөрсний овоолго	Хавар, намар	Жилд 2 удаа	50,000	100,000	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019.
		Ажилчдын хотхон орчим					
		Хогийн цэг					
		Уурхайн карьер					
		ЗҮТ					
2	Хөрсний хүнд металл (Cr, Cd, Pb, Ni, Zn агууламж)	Шимт хөрсний овоолго	Хавар, намар	Жилд 2 удаа	80,000	160,000	
		Ажилчдын хотхон орчим					
		Хогийн цэг					
		Уурхайн карьер					
		ЗҮТ					
Нийт зардал						260,000	

9.3 Усны чанарын хяналт шинжилгээ

Хүснэгт 21. Усны чанарын хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Ca, Mg, CL, SO4, NO2, К-ийн агууламж, амт, үнэр, өнгө, рН нийт ууссан хатуу бодисын хэмжээ,	Шүүрлийн ус	Хавар, намар	Жилд 2 удаа	100,000	200,000	

2	нийт хатуулаг	Ундны ус	Хавар, намар	Жилд 2 удаа	100,000	200,000	Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998
3		Хөөтийн булаг	Хавар, намар	Жилд 2 удаа	100,000	200,000	
Нийт зардал						600,000	

9.4 Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээ

Хүснэгт 22. Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалийн тоо Дундаж өндөр, см Бүрхэц	Төслийн талбайд	8 сард	Жилд 1 удаа	-	240,000	Мониторингийн цэгт 1x1 м хэмжээтэй торыг ашиглан, хоорондоо 50 м-ийн зайд 2 цэгт хийх, Мониторингийн судалгааны өмнө тухайн бүлгэмдэл болон талбайн фото зургийг авч баримтжуулах.
Нийт зардал						240,000	

9.5 Амьтны аймгийн хяналт шинжилгээ

Хүснэгт 23. Амьтны аймгийн хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
---	-----------------------------------	-------------------------	--------------------	----------------	---------------------	------------------	------------------------------------

1	Зэрлэг ан амьтдын мониторинг хийх	Уурхайгаас 10 км-ийн радиуст мониторингийн цэгүүдэд	Ш улиралд	Жилд 1 удаа	300,000	300,000	Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай хууль
Нийт зардал						300,000	

9.6 Дуу шуугианы хяналт шинжилгээ

Хүснэгт 24. Дуу шуугианы хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Дуу шуугиан	Ажилчдын хотхон	Сар бүр	-	30,000	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонголт хамгаалахад тавих ерөнхий шаардлага MNS 6768:2019
2		Уурхайн карьер	Сар бүр	-	30,000	
3		Засвар үйлчилгээний төв	Сар бүр	-	30,000	
4		Хөрсний овоолго	Сар бүр	-	30,000	
5		Уурхайн дотоод зам	Сар бүр	-	30,000	
Нийт зардал					150,000	

БҮЛЭГ 9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Байгаль Орчин, тогтвортой хөгжлийн газраас газар нэгжийн байгаль орчны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөлт, зохион байгуулалтыг хийж, мэргэжлийн удирдлагаар хангадаг.

Уурхайн удирдлагаас төлөвлөгөөт онд дараах ажлуудыг зохион байгуулна. Үүнд:

Хүснэгт 25. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2024			
			Сар	Сар	Сар	
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох газраар батлуулж, биелэлтийг хангах	200,000	Жилдээ	Жилдээ	Жилдээ	Байгаль орчны мэргэжилтэн
2	Ус ашиглах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээг байгуулах, гүйцэтгэлийг хангах, ус ашиглалтын мэдээ тайланг боловсруулан холбогдох газруудад хүргүүлэх, төлбөрийг төлөх	Гэрээнд зааснаар	Жилдээ	Жилдээ	Жилдээ	Байгаль орчны мэргэжилтэн
3	Хаягдал бохир усны дүгнэлт, хаягдал бохир ус зайлуулах зөвшөөрөл, гэрээг байгуулах, гүйцэтгэлийг хангах, төлбөрийг төлөх	Гэрээнд зааснаар	Жилдээ	Жилдээ	Жилдээ	Байгаль орчны мэргэжилтэн
4	Хог хаягдлын гэрээ байгуулж, гүйцэтгэлийг хангах	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт	Тухай бүрт	Тухай бүрт	Байгаль орчны мэргэжилтэн
5	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх	Гэрээнд зааснаар	Жилдээ	Жилдээ	Жилдээ	Байгаль орчны мэргэжилтэн
6	Байгаль орчны сургалт семинарыг зохион байгуулж, ажилчдыг хамруулах	200,000	Тухай бүрт	Тухай бүрт	Тухай бүрт	Байгаль орчны мэргэжилтэн
Нийт зардал		400,000				

БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа орон нутгийн иргэд болон төрийн байгууллагыг үнэн зөв бодит мэдээллээр хангахад оршино.

Хүснэгт 26. Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	Дундговь аймгийн БОАЖГ	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж тайланг хүргүүлэх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	11 дүгээр сарын 01-ний дотор	100,000	Уурхайн удирдлага, Байгаль орчны мэргэжилтэн	Дундговь аймаг
2	Баянжаргалан сум, багийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	11 дүгээр сарын 01-ний дотор	100,000	Уурхайн удирдлага, Байгаль орчны мэргэжилтэн	Баянжаргалан сум
Нийт зардал					200,000		

БҮЛЭГ 11. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО

Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажилд 55,400,000 төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 1,870,000 төгрөг, нийт 57,270,000 төгрөг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт 27. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний урьдчилсан зардал

Д/д	Хийгдэх ажлууд	Зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14,500,000
2	Нөхөн сэргээлтийн ажил	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	40,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговрын зардал	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах зардал	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулах зардал	200,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулах зардал	100,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,870,000
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	400,000
10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэхэд гарах зардал	200,000
Нийт		57,270,000



Аж ахуйн нэгжийн нэр: Монголын алт МАК
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: МУ-012199
Ашигт малтмалын төрөл: Чулуун
Баяжуулалтын технологи: Баяжуулалт хийгдэхүй

АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

Маяг-1.1



Төлөвлөгөөний он: 2024
ТЗЗҮ-ээр ашиглах нийт хугацаа: 27
Ашиглалтын хэд дэх жил: 11

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөв

№	Үзүүлэлтүүд	Бүтээгдэхүүний хэмжээ			Тайлбар
		Хэмжих нэгж	Бүтээгдэхүүний тоон утга	Экспортлох бүтээгдэхүүний хэмжээ	
1	2	4	5	6	7
1	2025 онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ				
	Олборлолт хэмжээ	мян. тн	1000		2025 оноос нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтанд орсоноор олборлолтын хэмжээг нэмэгдэнэ гэж тооцож.
	1.3.3 Урт Дөлт нүүрс	мян. тн	1000		
2	2026 онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ				
	Олборлолт хэмжээ	мян. тн	1500		
	1.3.3 Урт Дөлт нүүрс	мян. тн	1500		
3	2027 онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ				
	Олборлолт хэмжээ	мян. тн	1500		
	1.3.3 Урт Дөлт нүүрс	мян. тн	1500		

Төлөвлөгөө гаргасан: Б.Ламзав
Албан тушаал:

Хүлээн авсан: Х.Лхагвабаатар
Мэргэжилтэн:



Аж ахуйн нэгжийн нэр: Монголын алт МАК
Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-012199
Ашигт малтмалын төрөл: Чулуун

АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

Маягт-6.2

Төлөвлөгөөний он: 2024
Тухайн онд олборлох хэмжээ: 0.00



Уурхай, үйлдвэрийн усан хангамж

№	2	3	4	5	6	7	8	Тайлбар
1	Хэрэглэгчдийн жагсаалт						9	
1	Унд, ахуйн зориулалттай хэрэглээ, м3/жил	Унд, ахуйн зориулалттай хэрэглээ, м3/жил	Зөвөөр	мян.м3/жил	7.3657		0.00	Засгийн газрын 326 болон 327 тогтоолоор унд ахуйн усны төлбөр 0 төг болсон
2	Олборлох үйлдвэрлэлийн хэрэглээ, м3/жил	Олборлох үйлдвэрлэлийн хэрэглээ, м3/жил	Гүн (шүүрэл, худал)	мян.м3/жил	6.609		0.00	Уурхайн зам усалгааг уурхайн дотоод зам дагуу өдөр 1 удаа 120 хоног хийнэ. Шүүрлийн ус ашиглана.
3.1	Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хэрэглээ	ББҮ-Эргэлтийн усны хэрэглээ	-- Сонгох --	мян.м3/жил				Баяжуулах үйлдвэр байхгүй
3.2	Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хэрэглээ	ББҮ-Нэмэлт усны хэрэглээ	-- Сонгох --	мян.м3/жил			0.00	Баяжуулах үйлдвэр байхгүй
3.3	Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хэрэглээ	ББҮ-Нийт усны хэрэглээ	---	мян.м3/жил	0			Баяжуулах үйлдвэр байхгүй
3.4	Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хэрэглээ	ББҮ-ийн эргэлтийн усны эзлэх хувь	---	%				Баяжуулах үйлдвэр байхгүй
4	Байгаль орчин, нөхөн сэргээлт, м3/жил	Байгаль орчин, нөхөн сэргээлт, м3/жил	Гүн (шүүрэл, худал)	мян.м3/жил	1.2		0.00	Шүүрлийн ус ашиглана.
5	Ус шавхан зайлуулах хэрэглээ, м3/жил	Ус шавхан зайлуулах хэрэглээ, м3/жил	Гүн (шүүрэл, худал)	мян.м3/жил	146.59	166.50	24.41	см-80-50 200А-4 Цэжилгаан Нөсөс ашиглана. Хонгог 535М3 ус шүүрмүлтийн ажил хийгдэнэ.
6	Бусад /Авто зам, барилга, газар тариалан, г.м/ хэрэглээ	Бусад /Авто зам, барилга, газар тариалан, г.м/ хэрэглээ	-- Сонгох --	мян.м3/жил			0.00	
7	Нийт хэрэглээ	Нийт хэрэглээ	---	мян.м3/жил	161.7647		0.00	

* Баяжуулах үйлдвэргүй гэсэн сонголтыг хийвэл маягтын 3.1-3.4 хүртэлх мөр гарч ирэхгүй байхаар тохиргоо хийх.

Төлөвлөгөө гаргасан: Б.Ламзав
Ерөнхий инженер: Л.Булгантамир

Хүлээн авсан: Мэргэжилтэн:



Аж ахуйн нэгжийн нэр:
Ашигт малтмалын төрөл:
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар:

Монголын алт МАК
Чулуун
MV-012199

Ашигт малтмал газрын тосны газар

Төлөвлөгөөний он: 2024

Маягт-10



Байгаль орчны нөхөн сэргээлт

Д/д	Үзүүлэлт	Талбай		Эзэлхүүн		Зардлын хэмжээ		Тайлбар	Солбицол									
		Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга		Уртраг				Өргөрөг				Метрийн	
1	Техникийн нөхөн сэргээлт - Гадаад овоолго	га		м3		сая.төг		Нөхөн сэргээлт хийгдэхгүй										
									№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин	
									1	107	41	8.2	45	41	41.3	709093.15	5063648.09	
									2	107	41	15.5	45	41	44.4	709250	5063750	
									3	107	41	15.3	45	41	37.9	709250	5063550	
2	Техникийн нөхөн сэргээлт - Дотоод овоолго	га		м3		сая.төг		Дотоод овоолго байхгүй										
									№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин	
									1									
3	Биологийн нөхөн сэргээлт Шимт хөрс	га		м3		сая.төг		Шимт хөрсэнд нөхөн сэргээлт хийгдэхгүй										
									№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин	
									1	107	41	14.4	45	41	30.7	709538.754	5063327.045	
									2	107	41	15.8	45	41	29.1	709269.277	5063279.127	
									3	107	41	16.5	45	41	27.3	709287.497	5063223.566	
4	Биологийн нөхөн сэргээлт Биологи	га		м3		сая.төг		Нөхөн сэргээлт хийгдэхгүй										
									№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин	
									1									
5	Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт	га		м3		сая.төг	40	Орон нутгаас ирүүлсэн саналын дагуу										
									№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин	
1																		
6	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ	га	0.4	ш	2000	сая.төг	6	Уурхайн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.										
									№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин	
									1	107	41	43.99	45	41	49.805	709856.8459	5063935.8131	
									2	107	41	48.728	45	41	51.267	709957.7844	5063984.3982	
									3	107	41	45.812	45	41	48.401	709897.2843	5063906.1648	
7	Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг судлах, хамгаалах	га		м3		сая.төг	3	Уурхайн орчим хяналтын цэгүүд дээр хийнэ.										
									№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Град	Мин	
									1	107	68	38.736	45	69	25.866	708964.673	5063396.257	
									2	107	68	66.587	45	69	49.612	709172.656	5063667.348	
3	107	67	83.447	45	68	89.086	708547.882	5062973.213										
4	107	68	2.993	45	68	78.93	708703.853	5062865.478										
Нийт		га	0.40	м3	2,000.00	сая.төг	49.00											

Төлөвлөгөө гаргасан: Б.Ламзав
Албан тушаал:

Хүлээн авсан:
Мэргэжилтэн:

